

**“Трайнулар стар нев” ХХК**

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ  
ХЭРЭГЖИЖ БУЙ “НҮҮРС АЧИЖ, БУУЛГАХ ГААЛИЙН  
ХЯНЛТЫН БҮС” ТӨСЛИЙН 2023 ОНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХБАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Улаанбаатар хот  
2022 он**

**БАТЛАВ.**

БОАЖЯ-ны ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН

УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА:

**ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:**

“ТРАИНГУЛАР СТАР НЕВ” ХХК-ийн ЗАХИРАЛ  /WULANHU/



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ “НҮҮРС АЧИЖ,  
БУУЛГАХ ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС” ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Регистрийн дугаар: 6229883

ХЯНАСАН:

БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин,

Байгалийн нөөцийн удирдлагын газрын мэргэжилтэн:

БОЛОВСРУУЛСАН:

“Траингулар стар нев” ХХК-ийн мэргэжилтэн:



/Ц.ЭРДЭНЭСҮРЭН/

2022 он

## ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төслийн нэр:** “Нүүрс ачиж, буулгах гаалийн хяналтын бүс байгуулах”

**Төсөл хэрэгжүүлэгч:** “Трайнгулар Стар Нев” ХХК


**Регистрийн дугаар:** 6229883

**Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:** Монгол улс, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 6-р хороо, 13-р хороолол, К-7-31 тоот, Утас: +(976) – 95159242

**Төслийн байршил:** Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн Цагаан хад гэдэг газарт Тавантолгой-Гашуунсухайт авто зам дагуу байрлана.

**Төслийн зорилго:** “Трайнгулар Стар Нев” ХХК нь өөрийн эзэмшлийн Гаалийн хяналтын бүсэд 24.7 га талбайд нүүрс буулгаж хадгалж, ачих үйл ажиллагаа явуулах мөн автосомасволлуудын түлшний хэрэглээг хангах зорилгоор шатахуун түгээх станц байгуулах бөгөөд нүүрс экспортын хувьд гаалийн баталгаат агуулах, гадаад худалдаа тээвэрлэлт зуучлалын үйл ажиллагааны үйлчилгээг үр ашигтай явуулж байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй, нөлөөллийг “0” түвшинд барих, Монгол улсын нутаг дэвсгэрт мөрдөгдөж буй хууль дүрэм журмыг сахин биелүүлж урт хугацааны туршид Монгол улсын хөгжил дэвшилд жинтэй хувь нэмэр оруулагч байна.

Зураг 1. Төслийн талбайн байршил



**Хүснэгт 1. Төслийн үндсэн үзүүлэлтүүд**

"Трайнгулар стар нев" ХХК-ийн гаалийн хяналтын талбайн төсөл		
Төслийн талбайн хэмжээ	24,7 га	
Нүүрс ачиж буулгах талбай	Талбайн бүрэн хүчин чадлаараа 400 мян.тонн нүүрс хадгалах боломжтой. Хоногт 400 уртын машин нүүрс буулгаж, 200 богинын машин ачихаас гадна талбайд 200 машин зогсох бүрэн хүчин чадалтай.	
Ажиллах хүч /хүний тоо ажлын байрны нэр/ Нийт 14- Үүнээс:	Ажлын байрны нэр	Ажлын байрны тоо
	Ерөнхий менежер	1
	Нягтлан	1
	Механик инженер	1
	Пүүлэгч	1
	Ачигчийн оперотор	4
	Гар буулгагч	3
	Засварчин	1
	Тогооч	1
	Харуул	1
Ажилчдын амьдрах байр	Нийт 15хүн амьдрах боломжтой. Гадаа 00 ашигладаг. Ажилчдын ростер амралт 28/14 байна.	
Барилга байгууламж	<ul style="list-style-type: none"> <li>✚ Оффис, ажилчдын амьдрах байр,</li> <li>✚ Шатахуун түгээх станц,</li> <li>✚ Шалган нэвтрүүлэх байр</li> <li>✚ Засварын газар</li> <li>✚ Авто жингийн байр Авто жин</li> </ul>	
Дэд бүтэц	Монгол–Хятадын хилийн Гашуунсухайт, Ганц модны боомтууд байнгын ажиллагаатай ажиллаж байна. Гашуунсухайт боомт хүртэл 25 км хатуу хучилттай болон сайжруулсан шороон замтай.	
Усан хангамж	Унд ахуйд хэрэглэх усыг Өмнөговь аймаг Ханбогд сум Хайрхан 3-р баг Цагаан хадны булан сухайд байрлалтай иргэн Чулуунбаатартай 2019 оны 1 дүгээр сарын 1 өдөр гэрээ байгуулан ашиглаж байна.	
Хог хаягдал	Төслийг хэрэгжүүлэх үед хатуу, шингэн, хийн төрлийн хаягдал үүснэ. Үүнд ажилчдын ахуйн хэрэглээнээс үүсэх бохир ус, үйл ажиллагаанаас тогтмол үүсэх хатуу хог хаягдал, тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтын хий, хөрсөн зам, нүүрс буулгах задгай талбай дээр явагдах механик ажлаас үүсэх тоос, тоосжилт болон эрчим хүч, дулааны зориулалттай галлагаанаас үүсэх хийн хаягдал хамаарна.	
Холбоо мэдээлэл, хяналтын асуудал	Мобинет ХХК-ны интернет сүлжээг гэрээ байгуулан ашиглаж байна. Гаалийн хяналтын бүсд буусан нүүрсний бүрэн бүтэн байдлыг хадгалах мөн ачилтанд хууль бус тээвэрлэлт орохоос сэргийлж 6 цэгт хөдөлгөөнт, линзтэй аналок камерыг талбайн бүх хэсэг мөн пүүний дээд талуудад техникийн тэвш харж байхаар байрлуулан харуул болон талбайн менежер, пүүлэгчийн давхар байнгын хараа хяналтанд үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн аливаа хэрэг зөрчил аюулгүй байдлаас сэрэмжлэн 1000W-н тод гэрэлтүүлэг талбайг бүхэлд гэрэлтүүлж байхаар байрлуулсан.	

**Төслийн хүчин чадал:** Төслийн төлөвлөлтөөр нийт эзэмшлийн 24.7 га талбайн 18 га-д нүүрс буулгах талбай эзлэх бөгөөд авто жингийн талбай, шалган нэвтрүүлэх хэсэг, шатахуун түгээх станц /ШТС/, ажилчдын амрах байр, кемпийг ашиглах ба нүүрс ачиж буулгах талбайн гадна 200 машин зогсох хүчин чадалтай авто зогсоол байгуулахаар төлөвлөж байна. Төслийн хүчин чадал нь өдөрт 80-100 тонны даацтай 400 ш автосамсвол /уртын тээвэр/ нүүрс буулгах, 200 ш автосамсваль /богины тээвэр / нүүрс ачих хүчин чадалтай авто жин үзэх зогсоол.

Төслийн хүрээнд нүүрс ачиж буулгах талбай нь тасралтгүй ажиллагаатай байх ба Монгол улсын хууль тогтоомжуудад заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, цаг агаараас саатах зэргийг тооцож дараахь байдлаар ажиллах горимыг төлөвлөсөн.

## Хүснэгт 2. Төслийн ажиллах горим

№	Ажиллах горимын төлөвлөлт	2019
1	Жилийн хуанлийн өдрийн тоо	365
2	Жилийн хуанлийн сар	12
3	Жилийн хуанлийн цаг	8760
4	Өдрийн хуанлийн цаг	24
5	Баяр ёслолын өдрүүд	9
6	Цаг агаарын саатал	10
7	Жилд ажиллах хоног	346

### Техник, тоног төхөөрөмж:

Төсөл хэрэгжиж эхэлснээр ачигч болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжийг түрээсэлж ажиллана. Цаашид үйл ажиллагаагаа өргөтгөн ачигч 3ш болон үйлчилгээнд явах суудлын автомашин 1ш худалдан авахаар төлөвлөсөн. “Трайнгулар Стар Нев” ХХК-ны интернет сүлжээг гэрээ байгуулан ашиглаж байна. Гаалийн хяналтын бүсэд буусан нүүрсний бүрэн бүтэн байдлыг хадгалах мөн ачилтанд хууль бус тээвэрлэлт орохоос сэргийлж 6 цэгт хөдөлгөөнт, линзтэй аналок камерыг талбайн бүх хэсэг мөн пүүний дээд талуудад техникийн тэвш харж байхаар байрлуулан харуул болон талбайн менежер, пүүлэгчийн давхар хараа хяналтанд үйл ажиллагаа явуулна.

Нүүрсний орд газраас ихэвчлэн 80-100 тоннын даац бүхий авто тээврийн хэрэгслийг хүлээн авч нэг автомашины тэвшийг 30 минутад буулгана. Мөн ачилтын хугацаа ойролцоогоор 30 минут үргэлжилдэг ба өдөрт 400 автосомасвол нүүрс буулгаж, мөн 200 орчим автосомасвол нүүрс ачих хүчин чадалтай. Нүүрс ачиж буулгах 3 м<sup>3</sup> шанаганы багтаамжтай ковш 7 ширхэг, авто пүү ажиллана. Үүнээс гадна авто ковш буулгаж чадахгүй үлдэгдэл нүүрсийг автомашины тэвшнээс гар аргаар буулгана.

### Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

#### Физик газарзүйн онцлог:

Төсөл хэрэгжих Ханбогд сумын төв нь Өмнөговь аймгийн нутгийн зүүн урд хэсэгт Даланзадгад хотоос 250 км, Галбын уулын ар бэл дээр Их булаг хэмээх газар байрлах ба энэ нь далайн түвшнээс дээш 1120 м өндөрт оршино. Физик газарзүйн мужлалтаар Говийн их мужийн Дорнод говийн муж, Дорнод говийн хотгорийн тойрогт (МУ-ын Үндэсний атлас, 2009), байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн мужлалаар Дорнод говийн цөлөрхөг мужийн Дорнод говийн өмнөд хэсгийн тойрогт хамаарна.

Гадаргуугийн хэлбэр дүрсээрээ Монгол орны геоморфологийн мужлалаар Дундговь-Өмнөговийн мужийн Галба-Өөшийн говийн тойрогт хамаарах ба гарал үүслээрээ тэгширмэл газар, уулс хоорондын ба уулс дундах хотгор дахь элэгдэлийн гаралтай өргөдмөл гадарга болон голын хөндий дэх хурмал хурдаст хотос гадаргуу бөгөөд төсөл хэрэгжих орчинд ялимгүй сэргэж хэлбэршсэн, нэн хуурайшмал, тэгшрэлийн гадарга бүхий үлдмэл уулсын цав толгод голын хурдаст тал зонхилоно.

### **Геологийн тогтоц:**

Өмнөговь аймаг Монгол Алтайн нурууны төгсгөл хэсэгт оршино. Тус аймгийн газар нутаг нь далайн түвшинээс дээш 800-1300 м өргөгдсөн дунд зэргийн уулстай говийн бүсэд багтдаг учир хотгор гүдгэрийн ялгаа ихтэй, сайр гуу жалгаар газрын гадарга хүчтэй хэрчигдсэн байна.

Тус төсөл хэрэгжих талбайн захаар доод карбоны вулканоген-тунамал хурдас, хожуу карбон-доод пермийн вулканоген чулуулаг, харин төв хэсэгт нь дээд пермийн нүүрс агуулагч хурдас зонхилон тархсан ба хэсэг хэсэг жижиг талбайд юра, цэрд, палеоген, неогены настай тунамал, туфоген-тунамал, терриген хурдсууд тааралдана.

Дөрөвдөгч галавын сэвсгэр хурдас бүх талбайгаар харьцангуй өргөн тархалттай байна. Доод девоны өгөөмөр формацийн хурдас талбайн баруун өмнөд захын багахан талбайд тархах ба шаварлаг-цахиурлаг хурдас зонхилж, хүчиллэг болон суурилаг туф, зүсэлтийн доод хэсэгт хас чулууны үе тааралдана. Чулуулаг нь ерөнхийдөө бага зэрэг занаржсан. Хурдасны нийт зузаан 2100-5500 м хүрнэ. Доод карбоны Их Шанхай формацийн туф, дундлаг найрлагатай лавын давхарга бүхий терриген хурдас талбайн баруун хойт өнцөгт тархжээ. Вулканомикт, полимикт элсэн чулуу, шаварлаг алевролит, гравелит, олигомикт ба полимикт хөрзөн чулуу зүсэлтэнд зонхилно. Туф, туффит, дундлаг найрлагатай элсэрхэг, хайргархаг тефройдууд, андезитын лав зэрэг вулканоген хурдас хоёрдогч чанартайгаар зүсэлтэнд оролцоно.

### **Цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлт:**

Ханбогдын район бол манай орны хамгийн хуурай уур амьсгалтай, ургамал бүрхэвчээр ядуу нутаг. Энэ бүс нутагт уур амьсгалын хуурай байдлыг илтгэх гол үзүүлэлт болох дулаан улирлын хур тунадас, газрын гадаргын ууршуулах чадварын харьцаа 0.14-аас бага /Нацагдорж 2004, Нацагдорж, Гүнбилэг 2006/ байдаг байна. Уур амьсгалын ерөнхий шинж байдал нь цөлийн уур амьсгалын шинжтэй боловч уур амьсгал бүрэлдэхэд гадаргын хотгор гүдгэр ихээхэн нөлөөлнө.

Жилийн дундаж агаарын температур жилд  $0.037-0.058^{\circ}\text{C}$ /жил-ийн хурдтай нэмэгдэж байгаа, ерээд оны сүүлчээс дулааралтын хурд бүр ч эрчимжиж байгаа харагдана. Дулааралтын эрчим өвлийн улиралд 2000-аад оны үед суларсан, харин зуны улиралд улам нэмэгдэж байна /Нацагдорж 2010/. Харин сүүлийн 5 жилийн дундаж агаарын температурын явцыг олон жилийн дундажтай харьцуулахад дулааралтын эрчим суларсан ба агаарын температурын өвөл, зуны улиралд жигд бус өсөж буурсан үзүүлэлттэй байна. Хөрсний гадарга дээр өвлийн улиралд агаарынхаас  $0.5-1.5^{\circ}\text{C}$ -аар хүйтэн, харин 3-10 дугаар сарын хооронд  $2-6^{\circ}\text{C}$ -аар дулаан байдаг.

Төслийн районд жилдээ 25-30 өдөр бороо орох ба ихээхэн хуурай уур амьсгалтай. Жилийн дундаж харьцангуй чийгшил 46-52% орчим байх бөгөөд хавар 36-38% болж буурна. Жилдээ 140 орчим өдөр харьцангуй чийгшил 30%-иас доош орж хуурайшдаг.

Дутагдал чийгшил буюу агаарын тухайн үеийн усны уурын даралт ба ханасан уурын даралтын зөрөө өвлийн улиралд бага 1-2гПа-аас хэтрэхгүй байснаа агаарын температур өсч, чийг агуулах чадвар нь нэмэгдэх тутам даган өсч зуны улиралд 16-19 гПа болно. Үнэмлэхүй чийгшлийн жилийн явц ч мөн агаарын температурыг дагана.

Төслийн бүс нутаг бол манай орны хамгийн салхидуу газар нутгийн нэг бөгөөд жилийн дундаж салхины хурд 3.8-4.6 м/с, хаврын саруудын салхины дундаж хурд 3.3-5.9 м/с байдаг газар юм. Янз бүрийн хурдтай салхины давтагдлыг аваад үзвэл өвлийн улиралд 0-1м/с хурдтай салхи зонхилдог,

хаврын улиралд 4-5 м/с-ийн хурдтай салхины давтагдал ихээхэн өсч зонхилох байдалтай болдог байх юм.

### ***Усан орчин:***

Гаалийн хяналтын талбай орчимд түр зуурын урсгалтай гол горхи эсвэл тогтмол гадаргын усан сан байхгүй. Төслийн талбайн өмнөд болон зүүн, зүүн хойд талаар орших Гурван зээрд, Далан шар, Баруун тогоо, Зүүн тогоо овоо болон Шовон хүрэн уулсаас орж ирэх түр зуурын урсгал усны гольдролуудаар зун намрын эрчимтэй орсон борооны үед гадаргын урсац орж ирж жижиг тойрмууд үүсгэдэг. Төслийн талбайгаас дунджаар 15-20 км зайд Галбын говийн хөндийгөөр хур борооны дараа түр зуурын урсац үүсэж, зарим үед гол хэлбэртэй тодорхой хугацаанд урсдаг. Ийм голуудын тоонд Бөхтөр Хөөврийн гол, Хадан булаг, Адгийн сухайт гол багтана.

Судалгааны талбайд өрөмдсөн цооногуудад хөрсний ус илрээгүй. Тухайн талбай нь дунд ба эртний төрмөлийн хурдасаас бүрдэх мегаантиклинори түүний бүрэлдэхүүнд багтах өргөргийн сунаж тогтсон Ноёны хотон бүтцийн зэргэлдээ байрлах тул дээрх атираат бүтцүүдийн байрлах гадаргын өндөршлөөс шалтгаалан сэвсгэр хурдас бүхэлдээ хуурайшсан байдаг. Гүний уст үеүд нь хур тунадасны ус болон гольдролуудын дагуух урсацын нэвчилтээр тэжээгдэж байдаг.

### ***Хөрсөн бүрхэвч:***

Судалгаанд хамрагдсан нутаг дэвсгэр нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Төв Азийн их мужийн Говийн мужийн өргөрөгийн бүсшилийн цөлийн бор саарал хөрсний 12-р тойрогт хамрагдана. Энэхүү тойрогт нам уулс, толгодын хэсгээр эх чулуулгын илэрцтэй, дутуу хөгжилтэй сайр чулуурхаг цөлийн бор саарал /гөлтгөнөгүй/, тал хөндий, нам хотос хэсгээр цөлийн бор саарал, цөлийн мараалаг бор саарал, уугуул хэлбэрийн мараа хөрс, элсэн хөрс голлон тархана.

“Трайнулар Стар Нев” ХХК-ийн Гаалийн хяналтын талбайн хөрсөн бүрхэвч нь үйл ажиллагааны нөлөөгөөр буюу нүүрс ачиж буулгах үеийн нүүрсний овоолго, машин техникийн нөлөөгөөр элэгдэл, эвдрэлд өртөн төлөв байдлын ихээхэн өөрчлөлтөд орсон байна. Гаалийн хяналтын талбайн хөрс үйл ажиллагааны нөлөөгөөр ямар ч бүтэцгүй сул элсэн болон элсэнцэр голдуу сайр чулуу ихтэй, ургамлын бүрхэцгүй болсон тул автомашины хөдөлгөөнөөс үүссэн салхины нөлөөгөөр суларсан хөрс шороо хийсч, газрын гадаргын өнгөн хэсэгт цайвар сааралдуу тоосны нимгэн үе тогтсон байв.

Хөрсний бүтэц алдагдсан, үе давхарга нь нимгэрсэн, хөрс хийсч зөөгдөх үйл явц ихэссэнтэй уялдаж, талбайн зарим хэсгээр дэржигнүүртэй зам ихсэн чулууны тархалт их (60-70%) болсон байна. Гаалийн хяналтын талбайн нүүрс ачиж буулгах талбай болон зорчих хэсэгт гадаргын хөрс техноген нөлөөгөөр үүссэн салхины үйлчлэл болон машин техникийн хөдөлгөөнөөр овоолгын гадаргаас хийсэн нүүрсний нунтагтай холилдон алаг цоог бүрдэл үүсгэсэн байна.

### ***Ургамлан нөмрөг:***

Гаалийн хяналтын талбай байрлах бүс нутагт Монгол өвс, хазаар өвс, агь, шарилж, бударгана ургамал зонхилно. Зам дагуу хамхуул, лууль, хэд хэдэн зүйлийн шарилжууд ургасан байдаг. Ургамал нөмрөг нь ерөнхийдөө талхлагдаж шарилжийн эзлэх хувь их болсон байна. Тус нутаг нь манай орны цөлөрхөг хээрийн бүсэд багтдаг бөгөөд ургамлын төрөл зүйлийн хувьд төдийлөн баян биш юм.

Гаалийн хяналтын талбай нь Гашуун Сухайт боомтын хүртэлх нүүрс тээвэрлэх замын дагуу гаалийн хяналтын бүсийн талбайд байрших болон үйл ажиллагааны онцлогтой холбоотойгоор эдэлбэр газар болон түүний ойр орчмын ургамалжилт унаган төрхөө алдаж орчны бохирдолд тэсвэртэй хүмүүнсэг зүйлүүд голчлон ургасан бөгөөд талбайн хэмжээнд нийт ургамлын бүрхэц 10 % хүрэхгүй, 1.0 м<sup>2</sup> талбайд ургамллийн зүйлийн бүрэлдэхүүн 1-3, баглуур, бударгана, шаваг үетэн бүлгэмдэлтэй. Төсөл хэрэгжих ойр орчимд 100 м<sup>2</sup> талбайд бут сөөг 10–15 ширхэг, толгодын гүвээнд бут сөөг тохиолдоно. Нам хотос газарт хармаг, шаваг зонхилно.

#### ***Нийгэм эдийн засаг:***

Төсөл хэрэгжих Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутагт байрлах “Цагаан хад” нэртэй газарт Гаалийн хяналтын бүсийг 2006 оноос эхлэн Гашуун сухайт боомтын Нүүрсний уурхайн экспортод зориулж бий болгосноос хойш уг гаалийн бүсэд гаалийн хяналтын талбай, баталгаат агуулах, нүүрс тээвэрлэлтийн чиглэлээр тасралтгүй үйл ажиллагаа явагдаж ирсэн. 2022 оны 09 дүгээр сарын байдлаар Цагаан Хадны гаалийн бүсэд 1130 га бүхий талбайд 41 аж ахуйн нэгж, байгууллагын нүүрс ачиж буулгах баталгаат агуулах, экспортын болон бусад зориулалтаар гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаа явуулж байна. Мөн дунджаар 74 аж ахуйн нэгж зам тээвэр, түүний үйлчилгээтэй хамаарах үйл ажиллагаа явуулж байна.

#### **Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт**

***Агаарын чанар:*** “Нүүрс ачиж буулгах гаалийн хяналтын бүс” төслийн явцад нүүрс ачиж буулгах болон хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас ихээхэн хэмжээний тоосжилт үүсч агаарын чанарт сөргөөр нөлөөлнө. Түүнчлэн ашиглалтанд өртөж эвдэрсэн талбай, тээвэрлэлтийн зам болон нүүрсний овоолгоос үүсэх сул шороо нь тоосжилтын эх үүсвэрт хамаарна. Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах хүнд машин механизмын хөдөлгүүр, дулаан хангамжийн зуухны яндангаас гарах утаа зэрэг нь азотын ислүүд, хүхрийн ислүүд, угаарын хий болон бусад хортой хийнүүдийг агаар орчинд ялгаруулж агаарын бохирдол үүсгэнэ.

***Газрын гадарга, хөрсөн бүрхэвч.*** Төслийн газар ашиглалтаас хөрс, газрын гадаргад ихээхэн сөрөг нөлөө үзүүлнэ. Өнөөгийн төлөв байдлыг авч үзвэл төслийн барилга байгууламж, нүүрс ачиж буулгах талбай, авто зогсоол зэрэг газруудад хөрсөн бүрхэвч ашиглалтанд өртөж элэгдэл, эвдрэлд өртсөн байна. Цаашид үйл ажиллагаа явуулах хугацаанд газрын гадаргын эвдрэлд өртсөн талбайн хэмжээ нэмэгдэхгүй боловч хөрсний зулгаралт, элэгдэл эвдрэл нэмэгдэх бөгөөд цаашлаад хөрсний бүтэц, шинж чанарт өөрчлөлт орж хөрс үржил шимээ алдаж болзошгүй. Үүнээс гадна бензин, дизель зэрэг нефтийн бүтээгдэхүүн, хатуу, шингэн хаягдлаар хөрс бохирдох магадлалтай.

***Ургамлан нөмрөг.*** Одоогийн төлөв байдлыг авч үзвэл ургамлан нөмрөгийн хувьд нүүрс ачиж буулгах талбай болон барилга байгууламжийн суурьт өртөж устан, нийт талбайн хэмжээнд ургамлан нөмрөг хүчтэй талхлагдсан, ургамлын бүрхэвч 10-15% тай байна. Цаашид төслийн үйл ажиллагааны явцад ургамлан нөмрөг машин техникийн хөлд талхлагдах, төслийн талбай болон түүний орчимд хүний болон машин техникийн нөлөөгөөр хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөгийн өөрчлөлт, доройтол бий болох, замын болон нүүрсний тоос шороонд ургамлан нөмрөг дарагдаж ургамлын бодисын солилцоо алдагдах, фотосинтезийн идэвхи буурах цаашлаад өсөлт удаашрах, ургахаа болих зэрэг сөрөг нөлөөлөл үүсч болзошгүй.

***Усан орчин.*** Төслийн талбайд гадаргын болон гүний усны эх үүсвэр байхгүй. Төслийн үйл ажиллагааны явцад унд ахуйн болон зам ногоон байгууламжийн усалгаанд ус ашиглах ба усны хэрэглээг гүний худгийн эх үүсвэрээс хангахаар төлөвлөсөн. Төслийн үйл ажиллагаанаас гадаргын



болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл бага байх ба бензин дизель, бусад хортой бодис алдагдах, шингэн, ахуйн хог хаягдлыг ил задгай хаясан тохиолдолд хөрсөөр дамжин газрын доорх ус бохирдож болзошгүй.

**Амьтны аймаг:** Төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүн машин, техникийн төвлөрөл, хөдөлгөөн, дуу чимээ, тоос тоосжилт, доргио чичиргээ, гэрлийн нөлөө зэргээс тухайн нутаг дэвсгэрийн амьтад дайжих, тархац нутаг хумигдах, тэдгээрийн идэш тэжээл хомсдох гэх мэт шууд нөлөөлөл үүснэ.

**ТХГН, түүх соёлын дурсгалт зүйлс.** Төслийн талбай нь Говийн бага дархан газрын Б хэсгийн орчны бүсэд байршдаг. Төслийн талбай түүний орчимд одоогоор түүх соёлын дурсгалт зүйл, археологийн олдвор илрээгүй, хамгийн ойр орших дурсгалт зүйлс төслийн талбайгаас урд зүгт 5 км зайд байрших ба төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй. Төслийн үйл ажиллагаа нь ТХГН-г шууд нөлөөлөл үзүүлэхгүй боловч төсөл хэрэгжүүлэх үеийн хүний хөл хөдөлгөөн ихсэх, нүүрс зөөвөрлөх тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөн, шороон замын тоосжилт зэргээс бага зэргийн шууд бус болон дам нөлөөлөл нөлөө үзүүлж болзошгүй байна.

## **Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгасан агуулга бүтэцтэй байх шаардлагатай.

Төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 2-р хэсэгт тусгасны дагуу, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэрэгт тулгуурлан боловсруулав.

“Траингулар стар невь” ХХК нь үйл ажиллагаандаа Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг дагаж мөрдөнө.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт хэрэгжиж буй “Нүүрс ачиж, буулгах гаалийн хяналтын бүс” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

**Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
<b>Агаарын чанар</b>									
1	Нүүрс ачих, тээвэрлэх, буулгах үйл ажиллагааны явцад ажлын талбай дээр тоосжилт үүсэх, нийлүүлэгдэж түүхий эд болох нүүрснээс агаарт хийсч орчны бохирдол үүсгэх	Салхи тоосноос хамгаалах ургамал ойн зурвас бий болгох замаар салхины хурд хүчийг сааруулах, хөрсний өнгөн шороо, тоос хийсэхийг багасгах	Нүүрс хадгалах, дамжуулах талбайн эргэн тойронд	Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөөнд тусгасан				2023 онд	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5010-2001 Тоос. Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага. MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5002: 2000 Дуу, шуугиан. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. MNS 4994: 2000 Доргион. Доргионы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. MNS 0017-5-1-21: 1992 Дуу, чимээ. Авто тээврийн хэрэгслийн дуу чимээ. Дуу чимээний хүлцэх
2		Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн босох тоосыг бууруулахын тулд хурдны хязгаар тогтоож тэмдэгжүүлэх		Ширхэг	50.0	4	200.0	2023 онд	
3	Хүнд машин механизм болон бусад тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс агаар бохирдох, мөн хүнд даацын автомашины хөдөлгөөнөөс агаарт тоосжилт үүсэх нөхцөл бүрдэх	Тээврийн хэрэгслүүдийг тогтмол үзлэг, оношлогоонд хамруулж тэнцсэн тээврийн хэрэгслийг ашиглах, ялгаруулж буй утаанд хяналт тавьж ажиллах, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Төслийн талбай	ширхэг	30.0	-	1,200.0	2023 онд	

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт хэрэгжиж буй “Нүүрс ачиж, буулгах гаалийн хяналтын бүс” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
4	Тоосжилт, дуу шуугиан, хорт хий хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Ажилчдыг хувийн хамгаалах хэрэгслээр хангах /маск, иж бүрэн хувцас, чихэвч, нүдний шил г.м/	Дуу чимээ, тоосжилттой ажлын байран дахь ажилчид					2023 онд	төвшин, хэмжих арга. MNS (ISO) 13994: 2003 Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага. Агаарын тухай хууль
5	Агаарын тоосжилт, дуу шуугиан тархах	Агаарын чанарын мониторинг							MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага.
<b>Хөрс, газрын гадарга</b>									
6	Олон салаа зам гаргаж хөрс, газрын гадарга эвдэх	Олон салаа зам гаргахаас сэргийлж тэмдэг тэмдэглэгээ тавих, замуудыг хаах	Төслийн талбайд	ширхэг	50.0	5	250.0	2023 онд	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
7	Газар ашиглалтын зөв зохистой ашиглаагүйгээс хөрс, ургамлан бүрхэвчийн талхлагдлыг нэмэгдүүлэх, бохирдуулах	Газрын төлөв байдлыг сайжруулах, газрыг эмх цэгцтэй зохион байгуулах, ашиглалтын дор өртөх газрын хэмжээг хамгийн бага хэмжээнд байлгаж, газар ашиглалтын төлбөрийг цаг хугацаанд нь төлөх	Төслийн талбай- 24.7 га					2023 онд	
8		Хөрсний мониторинг хийх						2023 онд жилд 1 удаа	Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт хэрэгжиж буй “Нүүрс ачиж, буулгах гаалийн хяналтын бүс” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
<b>Усан орчин</b>									
9	Төслөөс усны чанарт үзүүлэх нөлөөлөл	Усны чанарын мониторинг хийх	Ундны усны эх үүсвэрт	ОХШХ-г тусгав.				2023 онд жилд 1 удаа	MNS 6148 - 2010 Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
10	Ундны усны нөөцийн бууралт	Төслийн ажилчдад усыг хэмнэлттэй ашиглах, хэмнэх талаар сургалт хийх	Төслийн ажилчдад	удаа	500.0	1	500.0	2023 онд жилд 1 удаа	Усны тухай хууль
<b>Амьтны аймаг</b>									
11	Төслийн үйл ажиллагаа явуулж буй талбай орчимд шувуу үүрээ засаж болзошгүй	Шувууд үүрлэсэн тохиолдолд ямар арга хэмжээ авах талаар ажилчдад сургалт оруулах	Төслийн талбай орчимд	удаа	500.0	1	500.0	2023 онд жилд 1 удаа	Амьтны тухай хууль
<b>Удирдлага, зохион байгуулалт</b>									
12	Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар ажил эхлэхийн өмнө сургалт, сурталчилгааг хийх	Төслийн ажилчдад	Удаа	500.0	2	1 000.0	2023 онд жилд 2 удаа	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ерөнхий шаардлага MNS 4968:2000

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт хэрэгжиж буй “Нүүрс ачиж, буулгах гаалийн хяналтын бүс” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
13		Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбар гаргаж, шинэчилж байх	Төслийн талбай	Ширхэг	500.0	2	1 000.0	2023 онд жилд 1 удаа	
<b>Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал</b>							<b>4 600.0 мян.төг</b>		

Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Биологийн нөхөн сэргээлт	Газар ашиглалтанд өртөөгүй буюу үйл ажиллагаа явуулахгүй байгаа талбайд зүлэгжүүлэлт хийх	Төслийн талбайд	Га	0.012	400.0	800.0	2023 онд	<ul style="list-style-type: none"> <li>- Ургамал хамгааллын тухай хууль</li> <li>- Биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал</li> <li>- MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах.</li> <li>- Техникийн ерөнхий шардлага</li> </ul>
2	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих	Орон нутгаас зааж өгсөн газар болон төслийн талбай орчимд мод тарих	Төслийн талбайд	Ширхэг	1500	20.0	30 000.0	2023 онд	
<b>Цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний зардал</b>						<b>30 800.0 мян.төг</b>			

Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай нь Говийн бага дархан газрын Б хэсгийн хязгаарлалтын бүсээс 2.7-3.5 км зайд байрлаж байна. Төслийн үйл ажиллагаанаас ТХГН-г шууд нөлөөлөл үзүүлэхгүй тул түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөгдөөгүй.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт хэрэгжиж буй “Нүүрс ачиж, буулгах гаалийн хяналтын бүс” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

**8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө**

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /мян.төг/	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Техник технологийн болзошгүй гэмтлээс шалтгаалсан осол	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Нийт төсөл хэрэгжих талбай, барилга байгууламжинд	-	Дотоод хяналтаар			Авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм
2	Болзошгүй гал түймэр, байгалийн гамшиг	Гал унтраах багаж хэрэгсэл байрлуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Бүх ажиллагсад	2	500.0	1 000.0	2023 онд жилд 2 удаа	Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1
3	Ажилчид үйлдвэрийн болон бусад өвчин, эмгэг тусах	Эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Бүх ажиллагсад	14	200.0	2 800.0	2023 онд жилд 1 удаа	Эрүүл мэндийн сайдын тушаал, дугаар 340- Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам
<b>Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал</b>				<b>3 800.0 мян.төг</b>				

**9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө**

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1		Хаягдал бохир ус, хатуу хог хаягдал, ажилчдын тосгоноос гарах хатуу,	Ажилчдын тосгон болон төслийн	Удаа	Байгууллага хоорондын гэрээ болон дотоод төлөвлөгөөгөөр			2023 онд жилд 1 удаа	- Хог хаягдлын тухай хууль - MNS 5344:2011

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт хэрэгжиж буй “Нүүрс ачиж, буулгах гаалийн хяналтын бүс” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
2	Ахуйн хог хаягдал	шингэн хаягдлыг зориулалтын цэгт ачуулж хэвших, бие засах газрыг стандартад нийцүүлэн барьж ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх	талбайд байршиж буй ариун цэврийн байгууламж						Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
		Ахуйн хатуу хаягдлын дахин боловсруулах боломжтой хэсгүүдийг ангилах, сортлох ажлыг ахуйн хаягдал үүсэх шатанд хэрэгжүүлж ангилж ялгасан хог хаягдлыг түр хадгалах цэгийг стандартын дагуу байгуулах	Төсөл хэрэгжих орчинд /ахуйн хог хаягдал/	Ширхэг	350.0	2	700.0	2023 онд жилд 1 удаа	
3	Хаягдал дугуй болон бусад техникийн хатуу хаягдал	Төслийн нутагт хадгалж хуримтлуулж байгаад дахин ашиглах байгууллагад тушаах	Төслийн талбай	Тн	Байгууллага хоорондын гэрээ болон дотоод төлөвлөгөөгөөр			2023 онд жилд 1 удаа	
<b>Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал</b>					<b>700.0 мян.төг</b>				



### 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
<b>Агаарын чанар</b>								
1	Агаарын бохирдлын (NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , CO) шинжилгээ	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 2 цэг сонгох	Хавар, намрын улирал тус бүр	Жилд 2 удаа	200.0	400.0	Агаарын чанарын стандарттай харьцуулж дүгнэлт гаргах	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, - MNS4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга
2	Нийт тоос, PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub> , нийт тоосонцор				300.0	600.0		
3	Агаарын дуу шуугиан				150.0	300.0		
<b>Хөрсөн бүрхэвч</b>								
1	Хөрсний эвдрэл, бохирдол Хүнд металлууд: Pb, As, Ni, Cd, Zn, Cu,	Төслийн талбайн 3 цэгээс	Хавар, намрын улирал тус бүр	2 удаа	50.0	150.0	Өнгөн хөрснөөс хүнд дээж аван хүнд элементийн бохирдлыг тодорхойлон стандарттай харьцуулан, хөрсний хими физик шинж чанарын өөрчлөлтийг тодорхойлон нөлөөлөлд өртөөгүй хөрсгэй тус тус харьцуулан тайлан боловсруулж дүгнэлт хийн зөвлөмж өгнө.	- MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, - MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, - MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга - MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага - MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга - MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн
2	Агрохимийн үзүүлэлтүүд: рН, ялзмагийн хэмжээ, NO <sub>3</sub> , SO <sub>4</sub> , P <sub>2</sub> O <sub>5</sub> , NH <sub>4</sub>	Төслийн өртөөгүй талбай болон төслийн талбай орчмоос	Хавар, намрын улирал тус бүр	2 удаа	35.0	140.0		

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт хэрэгжиж буй “Нүүрс ачиж, буулгах гаалийн хяналтын бүс” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
								зөвшөөрөгдөх дээд хэмжээ
<b>Усны чанар</b>								
1	Ундны усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Унд ахуйн усыг хангаж буй гүний худаг	Хавар, намрын улирал тус бүр	2 удаа	Ерөнхий хими- 60.0 Хүнд металлын шинжилгээ- 170.0	460.0	Ажилчдын унд ахуйн уснаас дээж аван усны физик, хими шинж чанар болон хүнд металлын шинжилгээ хийлгэн стандарттай харьцуулан тайлан боловсруулж дүгнэлт хийн зөвлөмж өгнө.	- MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ - MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага
<b>Томилолтын зардал, тайлангийн зардал</b>								
1	Мэргэжлийн байгууллагаар дээж авахуулан шинжлүүлэх		Хавар, намрын улирал тус бүр	2 удаа	1 000.0	2 000.0	Хээрийн судалгааны ажлыг талбай дээр хийж гүйцэтгэх	
2	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж тайлан боловсруулан дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулах		Хавар, намрын улирал тус бүр	2 удаа	1 000.0	2 000.0	Тайлан боловсруулах	
<b>Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал</b>						<b>6 050.0 мян.төг</b>		

**11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө**

Төлөвлөгөө тус бүр дээр хийхээр төлөвлөсөн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллана.

**12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө**

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан
Өмнөговь аймгийн Ханбогд сумын иргэд	Жилийн тайланг танилцуулах	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сард	Дотоод зардал	Төсөл хэрэгжүүлэгч, БО- ны мэргэжилтэн
Өмнөговь аймгийн БОАГазар	Жилийн тайланг хүргүүлж танилцуулга хийх ба санал авах		Жилийн эцсээр 1 удаа		
БОАЖЯ	Тухайн жилийн тайланг боловсруулан хүргүүлж дараагийн жилийн төлөвлөгөөнд санал авч төлөвлөгөөг батлуулна				

**13. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын задаргаа**

№	Ажлын нэр	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4650.0
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, тэрбум хөтөлбөр	30 800.0
3	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3 800.0
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	700.0
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	6 050.0
<b>6</b>	<b>Нийт зардал</b>	<b>46 000.0</b>